



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



## Агуулга

|       |   |    |
|-------|---|----|
| 1     | Аудитын гэрчилгээ .....   | 2  |
| 2     | Аудитын тайлан .....  | 4  |
| 2.1.  | Оршил.....  | 4  |
| 2.2.  | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....   | 4  |
| 2.3.  | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....  | 5  |
| 2.4.  | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....  | 5  |
| 2.5.  | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 6  |
| 2.6.  | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....   | 7  |
| 2.7.  | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....  | 7  |
| 2.8.  | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....  | 7  |
| 2.8.1 | Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....                                   | 8  |
| 2.8.2 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....       | 8  |
| 2.8.3 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар .....                   | 9  |
| 2.9.  | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                  | 10 |
| 2.10  | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга .....  | 10 |
| 2.11. | Шилэн дансны мэдээлэл.....  | 10 |
| 2.12. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....  | 10 |
| 2.13. | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....   | 11 |
| 3     | Менежментийн захидал.....   | 12 |
| 3.1   | Зардалтай холбоотой асуудал .....   | 12 |
| 3.1.1 | Илрүүлэлт:.....   | 12 |
| 3.1.2 | Эрсдэл: .....   | 12 |
| 3.1.3 | Өгсөн зөвлөмж: .....  | 13 |
| 3.1.4 | Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн .....   | 13 |
| 3.2   | Зорилтот түвшинтэй холбоотой асуудал .....  | 13 |
| 3.2.1 | Илрүүлэлт:.....   | 13 |
| 3.2.2 | Эрсдэл: Төлөвлөгөөнөөс гадуурх зарцуулалт, худалдан авалт хийх, төсөв хэмнэх зарчим алдагдах .....            | 13 |
| 3.2.3 | Өгсөн зөвлөмж: .....  | 13 |
| 3.2.4 | Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн .....   | 13 |
| 4     | Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                           | 14 |
| 4.1   | Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....   | 14 |
| 4.2   | Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....   | 16 |
| 4.3   | Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....   | 17 |
| 4.4   | Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....  | 18 |
| 4.5   | Аудит хийгдсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....   | 19 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| НББ      | Нягтлан бодох бүртгэл                                       |
| ТӨХК     | Төрийн өмчит хувьцаат компани                               |
| ЭХС      | Эрчим хүчний сайд   |
| ЭХЯ      | Эрчим хүчний яам  |



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД  
Ц.ДАВААСҮРЭН ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 854

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны төсвийн гүйцэтгэл, нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



## Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.БҮРЭНБАТ





## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн Зорилтот түвшин, зардал, авлага, өглөг, зохицуулалтын үнэ тариф боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 04 дүгээр сарын 08-наас 2019 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Б.Даваабаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/1310 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох нотлох зүйлст баталгаажуулан загвар аргачлалын дагуу горим сорилыг гүйцэтгэн баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ЭХЯ-ны талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан болно.

ЭХЯ нь "Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцлийг хангах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

ЭХЯ үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах;
2. Эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, бүс нутгийн шугам сүлжээ байгуулах;
3. Эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай, аюулгүй байдлыг хангах;
4. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;
5. Эрчим хүчний эх үүсвэрүүдийн түлшний баланс гаргах замаар нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг өргөжүүлэх;
6. Эрчим хүчний нүүрсний болон шинэ, хийн түлшний технологийг хөгжүүлэх, инновацийг дэмжих;
7. Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
8. Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх;
9. Эрчим хүч, түлш (эрчим хүчний нүүрс)-ний салбарт шинжлэх ухаан, технологи, эрчим хүчний балансын судалгаа, стандарт, норм, нормативын баримт бичиг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх явдал байна.

ЭХЯ-ны удирдлага Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох



бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
- Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд Засгийн газрын 2018 оны 335 дугаар тогтоолоор Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын 2.91-д “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын хувьцааны 70 хувийг ЭХЯ, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийг төлөөлөх этгээдийг томилж, чөлөөлнө” гэсэн заалтыг нэмж өөрчилсөн.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцээгүй байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Пластик” програм хангамж ашигладаг байна.

Харин үндсэн үйл ажиллагаа, дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

ЭХЯ-ны дотоод аудитын алба 39 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийжээ. Нийт 4,321.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 3,062.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 118 зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллажээ.



## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад ЭХС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 2,269,441.5 сая төгрөгийн 2 хувь буюу 45,388.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 36 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд аудитад бүрэн хамрагдсан.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

### Аудит хийсэн тайлангийн хэлбэр

Хүснэгт №1

| № | Байгууллагын нэр            | Санал дүгнэлт гаргасан | Гэрээгээр хийлгэсэн | Аудитын түүвэрт | Итгэл үзүүлсэн | Аудитад хамрагдаагүй |
|---|-----------------------------|------------------------|---------------------|-----------------|----------------|----------------------|
| 1 | Төсвийн шууд захирагч       | 1                      | 1                   |                 |                |                      |
| 2 | Төсөл, хөтөлбөр нэгж        | 5                      | 5                   |                 |                |                      |
| 3 | ТӨААН                       | 29                     | 29                  |                 |                |                      |
| 4 | Төсвийн ерөнхийлөн захирагч | 1                      | 1                   |                 |                |                      |
|   | <b>Дүн</b>                  | <b>36</b>              | <b>36</b>           |                 |                |                      |





Эх сурвалж: 2018 оны санхүүгийн аудитын тайлан

Аудитаар 31 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 5 тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргасан байна.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 138,185.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 115,789.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.2 хувь буюу 47.7 сая төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 60.4 хувь буюу 12,475.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 39.4 хувь буюу 9,872.5 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлуудыг холбогдох төсвийн захирагчдаар хүлээн зөвшөөрүүлж, аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн болно. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 92,509.7 сая төгрөгийн,
- ТӨХК-иудын санхүүгийн нэгтгэсэн тайланд 23,280.5 сая төгрөг, системийн хэмжээнд нийт 115,789.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад тус тус залруулсан болно.

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв:

#### Алдаа, зөрчил, шийдвэрлэлт

Хүснэгт №2

| № | Байгууллагын нэр | Залруулаагүй дүн |                 | Үүнээс:       |             |                 |                 |           |                |                   |     |                          |     |
|---|------------------|------------------|-----------------|---------------|-------------|-----------------|-----------------|-----------|----------------|-------------------|-----|--------------------------|-----|
|   |                  |                  |                 | Төлбөрийн акт |             | Албан шаардлага |                 | Зөвлөмж   |                | Хариуцлага тооцох |     | Хууль хяналт байгууллага |     |
|   |                  |                  |                 | Тоо           | Дүн         | Тоо             | Дүн             | Тоо       | Дүн            | Тоо               | Дүн | Тоо                      | Дүн |
| 1 | ТШЗ              | 4                | 5.3             |               |             | 1               | 1.8             | 3         | 3.5            |                   |     |                          |     |
| 2 | ТӨААН            | 118              | 20,676.0        | 9             | 47.7        | 29              | 12,474.2        | 80        | 8,154.1        |                   |     |                          |     |
| 3 | ТЕЗ              | 5                | 1,715.0         |               |             | 1               |                 | 3         | 1,715.0        |                   |     |                          |     |
|   | <b>Дүн</b>       | <b>126</b>       | <b>22,396.3</b> | <b>9</b>      | <b>47.7</b> | <b>31</b>       | <b>12,476.0</b> | <b>86</b> | <b>9,872.6</b> |                   |     |                          |     |

Эх сурвалж: 2018 оны санхүүгийн аудитын тайлан

### 2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллага, хувь хүнтэй холбоотой 2,507.2 сая төгрөгийн өглөг, авлагын үлдэгдлийг баталгаажуулж, тооцоо нийлээгүй, (хавсралт №1-ээр харуулав)

Худалдан авалт хийхдээ шууд гэрээ хийх, харьцуулалтын аргыг ашиглах, гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгох, тендерийг үндэслэлгүйгээр задлах, дутуу материал ирүүлсэн байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ нөхөн байгуулах, гэрээний үнээс илүү санхүүжилт олгох зэрэгт 2,124.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, (хавсралт №2-оор харуулав)

Зардлыг зарцуулахдаа төлөвлөгөөний дагуу бус, зардлын ангилал буруу, үр дүнг дүгнээгүй байхад урамшууллыг илүү олгодог, зарцуулалтын тайлан гаргаагүй 4,616.0 сая төгрөгийг зарцуулсан байна. (хавсралт №3-аар харуулав)

### **2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгасан болно.

#### **Асуудал 1:**

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 36 байгууллагаас Дулааны цахилгаан станц-3, Дулааны цахилгаан станц-4, Улаанбаатар дулааны сүлжээ, Хөвсгөл дулааны станц, Эрчим хүчний хөгжлийн төв "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т Төсвийн ерөнхийлөн захирагч түүний бүрэн эрх "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйн улмаас зөрчил гарсан байна.

**Шийдэл:** Албан шаардлага өгөх

#### **Асуудал 2:**

Нэг худалдан авагчийн загварын дагуу Эрчим хүчний зохицуулах хороо оны эцэст зохицуулалт хийснээс зарим харъяа байгууллагуудын батлагдсан зорилтот түвшин биелэхгүй болох эрсдэл гарч байна. Мөн оны эхэнд харилцагч байгууллагуудтай хийсэн борлуулалтын гэрээ зөрчигдөх үүнээс шалтгаалан хийсвэр дүнгээр найдваргүй авлага үүсч байна.

**Шийдэл:** Албан шаардлага өгөх

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Гадаад зээл, тусламжийн зардлыг сайдын багцын харилцах дансаар дамжаагүй тохиолдолд төсвийн гүйцэтгэлийн тайланд оруулж тайлагнах нь сайдын багцын зардлын нийт дүн хэтрэхэд нөлөөлөх магадлалтай байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны гарч байгаа тогтоолын дагуу дулаан, цахилгааны үнэ тарифт өөрчлөлт оруулахад судалгаа шинжилгээ бүрэн хийж, тухайн тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай байна.

### **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 5 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 726.4 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зорилтот түвшингийн үзүүлэлтийн орлогын биелэлт, зардлын гүйцэтгэл, батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг харъяа байгууллагаар нь авч үзвэл 2,615,297.4 сая төгрөг батлагдснаас 86.7 хувь буюу 2,269,441.6 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй гарч, 345,855.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

ЭХЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод хяналтын газар харъяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт жилд 2 удаа хяналт шалгалт хийж, 3 зөвлөмж өгсөн ба 167 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба гүйцэтгэл нь 95.2 хувьтай байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.



### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардалтай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Засгийн газрын 2017 оны 187 дугаар тогтоолоор өмнөх жилд мөн адил 17,150.0 сая төгрөгийг ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Алдагдлыг бууруулахаар батладаг боловч 1,715.0 сая төгрөгийг НӨАТ-аар суутган тооцдог нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.15-д "Төрөөс олгож байгаа төсвийн санхүүжилт, татаас, урамшуулалд", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх хэрэгтэй", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.2-д "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Зардлын зарцуулалтын ангилал болон бүртгэл буруу, төсөв хэмнэх зарчим алдагдах



### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Эрчим хүчний харьяа байгууллагуудад алдагдлыг бууруулах зорилгоор олгодог Татаас санхүүжилтээс НӨАТ суутган тооцохгүй байх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох арга хэмжээ авах

### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

## **3.2 Зорилтот түвшинтэй холбоотой асуудал**

### **3.2.1 Илрүүлэлт:**

Харьяа байгууллагуудын зорилтот түвшингийн төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, борлуулалтад мөрдөх үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хороо баталдаг байна. Эдгээр батлагдсан зорилтот түвшингийн төлөвлөгөө болон үнэ тарифын зохицуулалт нь хоорондын уялдаа холбоогүй, үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Зарим харьяа байгууллагууд батлагдсан зорилтод түвшингийн төлөвлөгөөг бүрэн хангаж ажиллаагүй байна.

**3.2.2 Эрсдэл:** Төлөвлөгөөнөөс гадуурх зарцуулалт, худалдан авалт хийх, төсөв хэмнэх зарчим алдагдах

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Засгийн газрын 2018 оны 335 дугаар тогтоолоор Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын 2.91-д “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын хувьцааны 70 хувийг ЭХЯ, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийг төлөөлөх этгээдийг томилж, чөлөөлнө” гэсэн заалтыг мөрдөх.

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| Код:  | Тайлангийн үзүүлэлт   | Тодруулга      | 2017 оны 12-р сарын 31 | 2018 оны 12-р сарын 31 |
|-------|---|----------------|------------------------|------------------------|
| 1     | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН   |                | 1,174,796,035.5        | 728,941,413.8          |
| 31    | МӨНГӨН ХӨРӨНГӨ  | 3а, 3б         | 65,803,830.9           | 56,213,532.0           |
| 33    | АВЛАГА  | 5а, 5б, 6а, 6б | 99,185,705.1           | 70,130,873.3           |
| 34    | УРЬДЧИЛГАА  | 7а, 7б         | 72,767,980.3           | 97,612,951.5           |
| 35    | БАРАА МАТЕРИАЛ  | 8а, 8б, 8в     | 54,549,438.6           | 63,026,744.0           |
| 36    | НӨӨЦИЙН БАРАА   | 9а             | 2,236,913.8            | 1,732,123.9            |
| 360   | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ   | 10             | 880,252,166.8          | 440,225,189.1          |
| 2     | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН   |                | 2,099,565,194.1        | 2,775,460,318.9        |
| 37    | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ   | 11а, 11б       | 14,630,123.3           | 13,488,103.4           |
| 37300 | Урт хугацаат зээл   |                | 14,630,123.3           | 13,488,103.4           |
| 39    | ҮНДСЭН ХӨРӨНГӨ  | 12а, 12б, 12в  | 2,084,935,070.8        | 2,761,972,215.5        |
| 39100 | Газар   |                | 0.0                    | 0.0                    |
| 39200 | Биет хөрөнгө  |                | 2,074,987,033.7        | 2,493,615,831.8        |
| 39300 | Биет бус хөрөнгө  | 13             | 8,651,156.4            | 266,978,595.2          |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/  | 14             | 1,296,880.7            | 1,377,788.5            |
| 3     | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II   |                | 3,274,361,229.6        | 3,504,401,732.7        |
| 4     | НИЙТ ӨР ТӨЛБӨР  |                | 748,417,617.1          | 893,715,746.8          |
| 41    | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР   | 15а, 15б       | 167,199,011.1          | 156,841,970.6          |
| 41200 | Богино хугацаат зээлийн өглөг   | 16а, 16б       | 16,093,019.1           | 50,589,433.7           |
| 41300 | Өглөг   | 17а, 17б       | 96,704,004.5           | 82,250,071.1           |
| 41400 | Урьдчилж орсон орлого   | 18а, 18б       | 54,401,987.5           | 24,002,465.7           |
| 42    | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР  |                | 581,218,606.0          | 736,873,776.2          |
| 42100 | Урт хугацаат үнэт цаас  | 19             | 0.0                    | 0.0                    |
| 42200 | Урт хугацаат зээл   | 20а, 20б       | 581,218,606.0          | 736,873,776.2          |
| 5     | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН  |                | 2,525,943,612.5        | 2,610,685,986.0        |
| 51    | Засгийн газрын хувь оролцоо   |                | 2,525,943,612.5        | 2,610,685,986.0        |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан |                | 52,569,454.7           | 15,864,664.9           |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/   |                | 1,196,158,729.7        | 1,283,357,813.1        |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/   |                | 6,940.0                | 6,940.0                |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/                                      |                | 117,615,309.5          | 341,558,515.5          |



Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|       |  |  |                 |                 |
|-------|--|--|-----------------|-----------------|
| 51200 | Хуримтлагдсан үр дүн                                   |  | 703,554,448.6   | 224,935,066.9   |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                       |  | 456,038,730.0   | 744,962,985.6   |
| 6     | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ<br/>ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> |  | 3,274,361,229.6 | 3,504,401,732.7 |



## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | Тодруулга | 2017оны 12-р сарын 31 | 2018 оны 12-р сарын 31 |
|------|--|-----------|-----------------------|------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                          |           | 441,086,062.0         | 598,368,003.9          |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 1а, 1б    | 330,485,453.3         | 541,755,073.8          |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              |           | 326,437,998.3         | 532,400,640.9          |
| 122  | Тусламжийн орлого  |           | 4,047,455.0           | 9,354,433.0            |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            |           | 110,600,608.7         | 56,612,930.1           |
| II   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                              | 2а, 2б    | 355,505,889.7         | 582,175,778.8          |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  |           | 314,277,427.5         | 341,372,087.3          |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          |           | 296,968,898.7         | 322,182,293.7          |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        |           | 2,564,382.3           | 2,422,600.5            |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           |           | 283,628.5             | 290,943.3              |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                |           | 279,021.5             | 273,432.7              |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         |           | 121,047.4             | 121,653.1              |
| 2105 | Нормативт зардал   |           | 5,535.0               | 2,675.4                |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        |           | 33,519.3              | 24,749.1               |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   |           | 129,233.7             | 102,688.1              |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж |           | 144,972,751.0         | 163,310,164.2          |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          |           | 148,579,780.0         | 155,633,387.2          |
| 211  | ХҮҮ  |           | 0.0                   | 1,923,134.8            |
| 212  | ТАТААС   |           | 17,149,933.3          | 17,149,933.3           |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   |           | 158,595.5             | 116,725.5              |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   |           | 41,228,462.2          | 240,803,691.5          |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)                    |           | 85,580,172.3          | 16,192,225.1           |
| IV   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН                          |           | 5,501,330.4           | 1,198,660.6            |
| V    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                          |           | 8,476,694.1           | 14,572,777.4           |
| VI   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)          |           | 82,604,808.6          | 2,818,108.2            |

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | Тодруулга | 2017оны 12-р сарын 31 | 2018 оны 12-р сарын 31 |
|------|--|-----------|-----------------------|------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)                   |           | 2,196,815,788.8       | 2,522,813,202.3        |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      |           | 2,057,115,180.0       | 2,466,200,272.2        |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              |           | 2,053,067,725.0       | 2,457,781,904.0        |
| 122  | Тусламжийн орлого  |           | 4,047,455.0           | 8,418,368.2            |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            |           | 139,700,608.7         | 56,612,930.1           |
| II   | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        |           | 1,959,988,075.4       | 2,273,551,625.4        |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  |           | 1,959,988,075.4       | 2,273,551,625.4        |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          |           | 1,913,579,336.8       | 2,270,773,839.1        |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        |           | 191,177,746.0         | 197,800,819.8          |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           |           | 50,574,055.8          | 57,946,633.1           |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                |           | 21,071,358.8          | 18,288,305.6           |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         |           | 1,061,643,609.0       | 1,215,975,352.2        |
| 2105 | Нормативт зардал   |           | 4,489.0               | 3,055.9                |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        |           | 37,402.0              | 24,840.2               |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   |           | 127,621.4             | 102,031.6              |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж |           | 576,634,931.8         | 779,769,035.4          |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          |           | 12,308,123.0          | 863,765.3              |
| 211  | ХҮҮ  |           | 0.0                   | 1,861,666.4            |
| 212  | ТАТААС   |           | 17,149,933.3          | 800,000.0              |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   |           | 29,258,805.3          | 116,119.9              |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)      |           | 236,827,713.3         | 249,261,576.8          |
| IV   | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)               |           | 1,413,032.2           | 4,514,526.9            |
| V    | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                |           | 177,892,728.3         | 290,338,371.6          |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   |           | 177,892,728.3         | 290,338,371.6          |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                      |           | 177,892,728.3         | 290,338,371.6          |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр                                      |           | 0.0                   | 0.0                    |
| VI   | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)    |           | -176,479,696.1        | -285,823,844.7         |
| VII  | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН   |           | -52,553,374.8         | 26,971,969.1           |
| 14   | Бусад эх үүсвэр  |           | 5,967,618.4           | 78,702,097.5           |
| 23   | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               |           | 41,228,462.2          | 35,558,767.3           |
| 25   | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ                        |           | 17,292,531.0          | 16,171,361.1           |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)        |           | 7,794,642.5           | -9,590,298.8           |
| 9    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         |           | 58,009,188.4          | 65,803,830.9           |
| 10   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        |           | 65,803,830.9          | 56,213,532.0           |

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт                             | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
